

ОЮУТАН ТӨВТЭЙ СУРГАЛТЫН АРГА БАРИЛЫГ ХҮН ТӨВТЭЙ ОНОЛТОЙ ХОЛБОХ НЬ

A PERSON-CENTERED THEORY WITH A STUDENT-CENTERED TEACHING METHOD CONNETING



С.Бямба-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн

Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн багш, ахлах дэслэгч

Хураангуй: Багш хүн оюутан төвтэй сургалтын арга барилыг сайн эзэмшихийн тулд хүн төвтэй онолыг эзэмшсэн байх ёстой. Хүн төвтэй онолыг эзэмших нь багш хүний хувьд чухал юм. Орчин үед багш төвтэй сургалтын арга барилаас татгалзаж, оюутан төвтэй сургалтын арга барилд шилжсэн. Өнөөдөр багш нар оюутнуудаа илүү сайн ойлгохын тулд хүн төвтэй онолыг ашиглах ёстой.

Түлхүүр үгс: Эрдмийн эрх чөлөө¹, суралцагч², багшийн³ хөгжил⁴;

Abstract: In order to master student-centered learning, a teacher must have a mastery of person-centered theory. Mastering person-centered theory is important for teachers. In modern times, the teacher-centered teaching method has been abandoned, shift to a student-centered learning approach. Today, teachers must use person-centered theory to better understand their students.

Keywords: Academic freedom, student, teacher development.

¹ Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлд Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа баримтлах 4 зарчмыг хуульчилсан байдаг. Мөн хуулийн 5.1.1 дэх хэсэгт “эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх” гэж заажээ.

² Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, УБ., 2023 он., 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт “...Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч” /цаашид “суралцагч” гэх/ гэж дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагч оюутан, магистрын хөтөлбөрөөр суралцагч магистрант, докторын хөтөлбөрөөр суралцагч докторантыг...” хэлнэ. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959041191>;

³ Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, УБ., 2018 он, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “багш” гэж Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээдийг” гэж заасан;

⁴ Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, УБ., 2018 он, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт “багшийн хөгжил” гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг” гэж заажээ. <https://legalinfo.mn/mn/detail/13532>;

ҮНДСЭН ХЭСЭГ:

Онол бол аливаа шинжлэх ухааны болон оюуны хөгжлийн суурь юм¹.

Орчин үеийн хүн төрөлхтний хөгжилд шинжлэх ухааны ололт амжилт маш том үүрэг гүйцэтгэсэн байдаг. Бид мэдээллийн эрин зуунд амьдарч байна. Шинжлэх ухааныг орчин үед нийгмийн болон байгалийн гэж ангилдаг. Байгалийн шинжлэх ухааны нэг салбар болсон мэдээллийн технологийн шинжлэх ухааны нэг судлагдахуун болсон интернэт сүлжээ дээр жишээ авахад бид интернэтийн тусламжтайгаар дэлхийн өнцөг булан бүрээс хүссэн цахим орчноор дамжуулан хүссэн сургуульдаа суралцах, дэлхийн мэдээ, кино, дуу хөгжим, бичлэг, худалдаа наймаа, арилжаа гэх мэт бүх төрлийн хүссэн мэдээллээ олж авахаас гадна алс хол байгаа иргэдтэй дэлхийн хаанаас ч холбоо барих боломжийг олгодог гээд бичээд байвал маш их зүйл бий. Интернэт бол шинжлэх ухааны ололт, амжилтын дөнгөж нэг хэсэг нь билээ.

Нийгмийн хөгжлийн суурь онол болох иргэншлийн буюу хүн төвт онол нь хүн байхын зэрэгцээ хүний оюун ухаан, оюун санаа юм. Оюун ухааныг хөгжүүлэх үндэс бол ахуйн эрх чөлөө юм.

Орчин цагийн Монгол улсын их, дээд сургуулийн оюутнууд маань багшийн өгч мэдлэгийг интернэт орчноос маш богино хугацаанд судлан мэдэж бие даан суралцах хандлага нэмэгдсэн.

Интернэт орчноос авч болохуйц түгээмэл байгаа мэдээллийг багш хүн оюутнууддаа заахдаа шинжлэх ухаанч сэтгэлгээгээр хүн төвтэй онолын үндсэн дээр хичээлээ заах нь маш чухал байна. Энэ нь оюутны сурч боловсрох эрхийг хүндэтгэж, эрдмийн эрх чөлөө олгох асуудал юм.

Оюутнуудад хичээлийг заахад багш төвтэй байх уу оюутан төвтэй сургалтын арга барилыг ашиглах уу гэдэг асуулт түгээмэл гарна. Багш төвтэй сургалтын идэвхтэй тал нь багш байна. Багш хичээлийг зааж оюутан, сонсогчид түүнийг сонсож сурахыг оролдоно. Оюутнууд идэвхгүй бөгөөд зөвхөн хүлээн авагчид байна. Багш хичээл дээрээ оюутнуудаас их асуулт асууж тэднийг хичээлд оролцуулж, сурагчдаас асуусан асуултынхаа хариултаас дүгнэлт гаргаж бүх оюутнуудыг хичээлд оролцуулсан ч энэ нь оюутан төвтэй сургалт биш бөгөөд мөн багш төвтэй сургалт юм. Шууд заах ба асуулт хариултын байдлаар явагддаг хичээл нь багш төвтэй сургалтын арга барил байдаг.

Сурагч төвтэй заах аргад оюутнуудад сурах орчин бүрдсэн газарт мэдлэгийг өөрсдөө бий болгоно. Багшаас асуулт асууна, түүнээс тусламж авна.

¹ С.Отгонжаргал. /МУИС, доктор (Ph.D), профессор/ “Багшийн оюуны хөгжилд онолын гүйцэтгэх үүрэг” сэдэвт илтгэл., Багшийн хөгжил XXI зуун багш, судлаачдын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-IX „УБ.,2024 он., 164 дахь тал;

Багшийн үүрэг асуултанд хариулах, ямар нэг хүндрэлтэй учрахад нь тусалж чиглүүлэх юм. Гэхдээ энэ асуултууд нь оюутнуудаас бэлдэж боловсруулсан асуулт байна. Нээлт хийх арга зам заах, жүжигчилсэн сургалт явуулах, туршилт хийх маягаар сургалт явуулах болон тоглоомчилсон сургалт нь оюутан төвтэй сургалт юм.

Оюутнуудаа бие даан хичээлээ хийхэд нь туслах, эрдмийн эрх чөлөөг олгож, оюутнуудын хийсэн даалгавар, дасгал ажилбар, асуултуудад оновчтой хариултууд өгч тухайн хичээлийн агуулгыг улам төгөлдөржүүлж, багшаас шавиа хайрлах хүнлэг мэдрэмжтэй, оюутны үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олгох нь хүн төвтэй онолын хэрэгжүүлж чадаж байгаа илрэл билээ.

Цахим орчноос цуглуулж болох маш их мэдээллээс багшийн зааж байгаа хичээлийн лекц, семинарын хичээлийн ялгаа юу байж болох вэ? гэдэг асуулт урган гарна. Багш хүн нэгдүгээрт Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 880 хуулиас өөрт хамгийн ойр түгээмэл хэрэглэх хуулийг судалсан байх ёстой. Үүнд:

Монгол улсын Үндсэн хууль /1992 он/, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль /2018 он/, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /2006 он/, Оюуны өмчийн тухай хууль /2020 он/, Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга /2023 он/, Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2023 он/, Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга /2021/, хэрвээ төрийн өмчийн сургуульд багшилдаг бол Монгол улсын Төрийн албаны тухай хууль /2017/ гэх мэт олон хууль бий.

Мөн хуулийн сургуулийн багш бол оюутнууддаа хандан холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд харьцуулан судлах, зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болох хууль тогтоомжийг хэрхэн ашиглах талаар чиглүүлэн заах нь чухал юм.

Багшийн хувьд Монгол улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт, Монгол улсын иргэний 17 эрх, үндсэн 4 үүрэг, журамт 4 үүргээ мэддэг байхаас эхлэн багшийн оюутнаа хэрхэн мэдэрч хичээлээ заах эсэх нь хамаарна. Тухайлбал,

Монгол улсын Үндсэн хуулийн¹ 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэгт “...Монгол улсын иргэн сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно...” гэж тунхаглан заасан байдаг.

¹ Монгол улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “...Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...” гэж, мөн хуулийн 14.2 дахь хэсэгт “...Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна...” гэжээ.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй, хэнийг ч ялгаварлан гадуурхаж үл болно гэж заачихсан байхад зарим багш нар тухайн оюутныг хичээлээс 5-10 минут хоцорсны төлөө хичээлд нь суулгахгүй, хичээлд суугаагүй гэж тэмдэглэдэг үе нэгэн цагт байсан.

Орчин цагт их, дээд сургуулийн багш нар би төвтэй үзлээс ангижирч оюутны сурч боловсрох эрхийг нэгдүгээрт тавьж оюутан бүртээ нэг бүрчлэн харилцаж, хичээл хийхэд нь чиглүүлэгч болж өгдөг нь хүн төвт онол Монгол улсад хөгжиж байгаагийн нэгэн илрэл юм.

Хүн төвтэй онолыг задлан үзвэл онолын үндсэн гол үзэл баримтлал нь:

➤ Хүн, оюун ухаан, оюун санаа, эрх чөлөө, үнэн, хувийн өмч байдаг.

Хүн төвтэй онол нь хувийн өмчийг үгүйсгэдэггүй, нийгмийн анги давхаргад хуваадаггүй, хүмүүс хоорондоо антогонист зөрчил байхгүй гэж үзэхийн дээр ноён ч бай, боол ч бай эрх тэгш хүн гэж үздэг¹.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 2023-2024 оны хичээлийн жилд 64 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 33 буюу 51.6 хувь нь их сургууль, 30 буюу 46.8 хувь нь дээд сургууль, 1 буюу 1.6 хувь нь коллеж байна. Нийт их, дээд сургууль, коллежийн 16 буюу 25 хувь нь төрийн өмчийн, 45 буюу 70 хувь нь хувийн өмчийн, 3 буюу 5 хувь нь олон нийтийн шашны өмчийн сургалтын байгууллага байна².

Хууль зүйн боловсрол олгох чиглэлээр Их Засаг олон улсын их сургууль, МУИС, ОТИС, ДХИС, Шихихутуг, Орхон, Олон улсын Улаанбаатар их сургууль зэрэг 14 сургууль эрх зүйч мэргэжилтэн бэлтгэж байна³.

Монгол улсад 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа нийт 145,000 гаруй суралцагч байна.⁴ Оюутан бүр сургуулиа амжилттай төгсөж ажлын байранд өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ ажил, орлоготой болох нь ажилтан болох зорилго тээдэг бизээ.

¹ С.Отгонжаргал. /МУИС, доктор (Ph.D), профессор/ “Багшийн оюуны хөгжилд онолын гүйцэтгэх үүрэг” сэдэвт илтгэл., Багшийн хөгжил XXI зуун багш, судлаачдын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-IX.,УБ.,2024 он., 165 дахь тал;

² <https://www.meds.gov.mn/post/134647> Дээд боловсролын 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээ;

³ В.Оюумаа. Хууль зүйн туслалцааны төвийн захирал, доктор (Ph.D), профессор., “Монгол улсын хууль зүйн боловсрол олгох тогтолцооны өнөөгийн байдал сэдэвт илтгэл”., Хууль зүйн боловсролын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.,УБ.,2023 он., 11 дэх тал;

⁴ Их, дээд сургууль, коллежид нийт 145,345 суралцагч суралцаж байна. Нийт суралцагчдын 80,133 буюу 55.1 хувь нь төрийн өмчийн, 57,258 буюу 39.4 хувь нь хувийн өмчийн, 7,954 буюу 5.5 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна

Багшийн хүний эрхийн мэдрэмж хэдий чинээ их байна, төдий чинээ оюутан, суралцагчаа хайрлан энэрэх мэдрэмж өндөр байна.

Багш хүн Монгол улсын боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заасан 8 эрхийг эдэлж, 18 үүргийг хэрэгжүүлдэг байх ёстой. Хуульд заасан багшийн эрхийг жагсаан бичвэл:

1. Эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;

2. Судалгаа шинжилгээний ажил хийх;

3. Жил тутам холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

4. Боловсролын сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх болон шийдвэр гаргахад санал өгөх;

5. Хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;

6. Хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;

7. Цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах;

8. Хуульд заасан бусад.

Хуульд заасан багшийн үүргийг дурьдвал:

1. Суралцагчид тогтоосон хугацаанд сургалтын хөтөлбөр, агуулгыг чанартай, бүрэн эзэмшүүлэх;

2. Суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;

3. Суралцагчийн чадамжийг бодитой үнэлэх, тэдний авьяас, хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг судлан суралцахуйг дэмжих;

4. Суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэн дэмжих;

5. Суралцагчаа хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;

6. Хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих;

7. Багшийн мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэх;

8. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

9. Сургалтад цахим технологи, хэрэглэгдэхүүнийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад цахим системийг ашиглах;

10. Ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;

11. Суралцагчийн эрхийг зөрчих болон сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, багш, удирдах ажилтан хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах үйлдэл гаргахгүй байх;

12. Байгууллагын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, бусад багш, ажилтан, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

13. Улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

14. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

15. Суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

16. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

17. Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

18. Хуульд заасан бусад.

Монгол улсын Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль 2023 онд батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамнаас их, дээд сургуулийг олон улсын жишигт нийцүүлж судалгааны их сургууль¹ болгон өөрчлөх шаардлага тавигдаж ирсэн.

Багшийн судалгаа шинжилгээний ажил хийх эрхийг хуульчилж өгсөн нь Монгол улсын боловсролын тогтолцоо шинжлэх ухаан чухал байр суурьтай байгаагийн нэг илрэл юм.

Багшийн үүргийн хувьд суралцагчид тогтоосон хугацаанд сургалтын хөтөлбөр, агуулгыг чанартай, бүрэн эзэмшүүлэх, суралцагчийн ялгаатай хэрэгцээ,

¹ Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, УБ., 2023 он., 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт "судалгааны их сургууль" гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг" гэж заажээ.

сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх, суралцагчийн чадамжийг бодитой үнэлэх, тэдний авьяас, хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг судлан суралцахуйг дэмжих, суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэн дэмжих, суралцагчаа хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх, хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих зэрэг хуульчлан зааж өгсөн үүргүүд багшийг ямар ч үед хүний эрхийн мэдрэмжтэй байх ёстой гэдгийг зааж байна.

Багш хүн хүний эрхийн мэдрэмжтэй, багшийн эдлэх эрх, хүлээх үүргээ мэддэг, оюутантай хүнлэг харьцдаг, оюутнаа мэдэрдэг байх нь чухал юм. Багш хүний хөгжил бол оюутнаа мэдэрч харилцахаас шууд хамаардаг гэж бодож байна.

Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт "багшийн хөгжил" гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг" хэлнэ гэж заажээ.

Технологийн эрин зуунд багшийн өгч байгаа хичээл, сургалт, даалгаварыг оюутнууд интернэт орчноор дамжуулан мэдээллийг богино хугацаанд олж мэдэж байгаа өнөө цагт оюутан төвтэй сургалтын арга барилыг тасралтгүй хэрэгжүүлж, оюутныг зөв удирдаж чиглүүлж, цэгцтэй мэдлэгийг олгоход хүн төвт онолын хэрэгцээ, шаардлага урган гарна.

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино..." гэжээ.

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "...Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино..." гэж заасан байдаг.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль, дээд сургууль, коллежид бүрэнд дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг түүний мэдлэг, чадвар, төлөвшилтийн үнэлгээ, сурах чадварыг харгалзан элсүүлнэ¹.

Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчдад шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм

¹ Б.Батсайхан, М.Дэлгэржав. "Боловсрол судлалын тайлбар толь", УБ., 2019 он., 62 дахь тал;

шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хүний гүйцэтгэлийн технологийн салбарын судлаачид болох Гильберт (1978), Портер, Лолер (1968), Рамлер, Браче (1990) нар гурван гол зүйл гүйцэтгэлд нөлөөлнө гэж үздэг байна. Эдгээр гурван зүйл нь чадвар, боломж, сэдэл ажээ.

Д.Ванчигсүрэн /1992/ “...Сургалтын технологи гэдэг ухагдахуун нь ...дидактик бүтцийн хүрээнд өөртөө сургалтын зорилго, агуулга, нөхцөл, хэрэглэгдэхүүн, түүнийг зохион байгуулах хэлбэр, багш, сурагч, сургалтын арга, үр дүн гэсэн олон бүрэлдэхүүн хэсгийг агуулах өргөн хүрээтэй ухагдахуун юм...” гэж тодорхойлсон.

Эрдэмтэн В.С.Леднев сургалтын агуулга нь бие хүний шинж чанар дэвшин өөрчлөгдөх үйл явцын агуулга юм¹ гэж тодорхойлсон байдаг.

Сургалтын агуулга нь хувь хүний эзэмшвэл зохих мэдлэг чадвар, туршлагаар илэрч баталгаажсан тасралтгүй хөгжиж байдаг оюуны бүтээл гэж үзэхээр байна.

Сургалтын агуулгыг тодорхойлох хоёр хандлага байдаг.

Нэгдүгээрт. Мэдлэгт чиглэсэн гэж нэрлэгддэг бөгөөд чадвар, дадал, ур чадвар, хандлага төлөвшүүлэхээс илүү мэдлэг үнэ цэнэтэй гэж үздэг.

Хоёрдугаарт. Бие хүнд чиглэсэн буюу хүн өөрийнхөө оюун санааны, соёлын болон амьдралын хэрэгцээг хангах зорилгоо биелүүлэх бололцоотой байх, боловсролын орон зайд өөрийгөө хөгжүүлэх, хэрэгжүүлэх учиртай гэж үздэг.

Хүнээсээ тасархай мэдлэг биш, хүн нь өөрөө үнэ цэнэтэй байх, суралцагчид агуулгын зарим хэсгийг чөлөөтэй сонгох, сургалтын явцад суралцагч өөрийгөө хөгжүүлэх, илэрхийлэх боломжтой байх шаардлагатай болж байна².

Сургалтын агуулгыг тодорхойлохдоо хүмүүнлэг ёсны зарчим болон шинжлэх ухааны үндэслэлтэй байх, прагматик байх, суралцагчдын нас, сэтгэц, хувийн боломж, боловсролын төвшинг харгалзах, түүхэн, тогтолцоотой, хүртээмжтэй байх зэрэг зарчмыг баримтлах хэрэгтэй.

1. Хүмүүнлэг ёсны зарчим. Хүн төрөлхтөний үнэт зүйлс, эрүүл мэнд, хүний чөлөөт хөгжлийг дээдлэн сургалтын агуулгыг сонгон бүтэцлэх асуудал багтана.

¹ Ж.Даваа, “Сургалтын технологи”, УБ., 2018 он., 18 дахь тал;

² Мөн тэнд., 19 дахь тал;

2. Шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчим. Сургалтын агуулгад шинжлэх ухааны мэдээлэл, шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололт, амжилтыг оновчтой тусгаснаар биелэлээ олно.

3. Прагматик байх зарчим. Сургалтын агуулга амьдрал, практиктай холбоотой, эрэлт хэрэгцээт мэдлэг, чадвар, дадал, хандлагаар баян байхыг шаарддаг. Янз бүрийн насны суралцагчдын боловсролын хэрэгцээ, сонирхлыг харгалзан, тэдний сэтгэц, хувийн боломж, боловсролын төвшинд сургалтын агуулга тохирч байх нь нэн чухал байдаг.

Судлаач багш нар Хүн төвтэй онолоор баримжаалан судалгаа хийвээс бусад орны эрдэмтэн судлаач нартай нэг түвшинд эрдмийн ажлаа хийх боломж нээгддэг. Хаана шинжлэх ухаанчаар маргаж байна тэнд ирээдүй нээлттэй байдаг, тэнд аливаа судлагдахуун амьд, амьдралтай харилцаа тогтож байдаг¹.

ДҮГНЭЛТ

Их, дээд сургуулийн багшаас оюутанд чиглэсэн сургалтыг зохион байгуулахдаа сургалтын арга барилыг багш төвтэй байхаас илүүтэй оюутан төвтэй байлгаж, оюутныг бие даалгаж сургах нь чухал юм. Мөн багш хүн бүр Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа багшид хэрэглэгдэх хууль тогтоомжийг судалдаг, оюутны эрхийг хүндэтгэдэг, хүний эрхийн өндөр мэдрэмжтэй байх нь хүн төвтэй онолыг хэрэгжүүлж байгаа хэрэг юм.

Ялангуяа лекцийн хичээл бол зөвхөн багш төвтэй сургалт гэж үздэг. Харин семинарын хичээл дээр багш хүн оюутнаа сайн сонсож, оюутан төвтэй сургалтын арга барилыг сайн хэрэгжүүлж, оюутнаар бие даан судалгаа шинжилгээ хийлгэж хөгжүүлж боломжийг олгодог. Монгол улсын Боловсролын бодлого нь Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дамжуулан их, дээд сургуулиудыг судалгааны их сургууль болгох, эрдмийг эрх чөлөөг эрхэмлэх зарчмын дагуу багш хүн бүр судлаач байх хэрэгцээ шаардлагыг баталгаажуулсан. Мөн багш хүний эрхийг баталгаажуулж өгөхдөө судалгаа шинжилгээ хийх эрхийг хуульчилсан нь ололттой байна. Багш хүн бүр тасралтгүй хөгжих боломж нь судлаач багш байхад оршихын зэрэгцээ оюутан төвтэй сургалтаар дамжуулан багш, оюутан хоёр хоёулаа хөгжих боломж олгодог. Эрдмийн эрх чөлөө эрхэмлэсэн багш нар оюутнуудынхаа судалсан судалгаа, мэдээ мэдээллийг харилцан солилцож мэдлэгээ хуваалцаж байгаа нь оюутан төвтэй сургалтын арга барилын мөн чанар болно.

Оюутан төвтэй сургалтын арга барилыг хэрэгжүүлж явцад багш хүн оюутнаа бие даан хичээл хийх, судалсан мэдээллээ багшаасаа асуух, мэдээллийн

¹ С.Отгонжаргал. /МУИС, доктор (Ph.D), профессор/ “Багшийн оюуны хөгжилд онолын гүйцэтгэх үүрэг” сэдэвт илтгэл., Багшийн хөгжил XXI зуун багш, судлаачдын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-IX „УБ.,2024 он., 167 дахь тал;

үнэн эсэхийг багшаар дамжуулан баталгаажуулж авах үйл явцад багш хүн оюутны сурч боловсрох эрмэлзэл, эрдмийн эрх чөлөө рүү тэмүүлж байгаа хүчин чармайлтыг үнэлж байгаа нь хүн төвтэй онолыг хэрэгжүүлэн ажилласны илрэл болно.

САНАЛ:

1. Багш нар сургалтын агуулгыг тодорхойлохдоо хүмүүнлэг ёсны зарчим, шинжлэх ухааны үндэслэлтэй байх, прагматик байх зарчмыг тасралтгүй хэрэгжүүлэн оюутнуудын цуглуулсан мэдээлэлд хүндэтгэлтэй хандаж, хичээл зүтгэлийг нь үнэлж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэнд нийцсэн, практик амьдралд хэрэгжсэн эсэх зэрэгт дүгнэлтийг тухай бүр хийх.

2. Судалгааны их сургуулийн багш нар судлаач багш байж, багшийн судалгаа шинжилгээ хийх эрхээ хэрэгжүүлж, тасралтгүй хөгжих.

3. Багш нар эрдмийн эрх чөлөөг эрхэмлэж, Б цагийн жишиг нормативд баригдалгүй давуулан биелүүлж, судлаач багш байж, эрдэм шинжилгээ судалгааны ажлаар манлайлан оюутнууддаа үлгэр дууриалал болох.

4. Оюутан шавь бүрээ оюутан төвтэй сургалтын арга барилаар дамжуулан судлаач оюутан болгоход анхаарах.

Эх сурвалж

➤ Хууль тогтоомж, эрх зүйн акт:

1. Монгол улсын Үндсэн хууль.,УБ.,1992 он;
2. Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль.,УБ.,2018 он;
3. Монгол улсын Боловсролын ерөнхий хууль.,УБ.,2023 он;
4. Монгол улсын Дээд боловсролын тухай хууль.,УБ.,2023 он;
5. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Босго оноо тогтоох тухай” А/138 дугаар тушаал;

➤ Ном сурах бичиг, судалгаа:

1. Б.Золзаяа, Д.Цогзолмаа. “Дээд сургуулийн сургалтын технологи”.УБ.,2007;
2. Ч.Эрдэнэбаатар, Ж.Сарангэрэл, С.Цэндээхүү. “Сургалтын арга барил, технологийн шинэчлэлийн асуудал”.УБ.,2011 он,
3. Ш.Ичинхорлоо, “Сургалтын онол, хэрэглээ”.УБ.,2013 он;
4. Ж.Даваа, “Сургалтын технологи”.УБ.,2018 он;
5. “Хууль зүйн салбарын одоо ба ирээдүй сэдэвт судлаачдын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл” /ДХИС/,УБ.,2021 он,

6. Б.Батсайхан, М.Дэлгэржав. “Боловсрол судлалын тайлбар толь”, УБ., 2019,

7. “Багшийн хөгжил ХХI зуун багш, судлаачдын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-IX” /ИЗОУИС/, УБ., 2024 он;

➤ **Цахим сайт:**

1. <https://www.meds.gov.mn/>;
2. <https://www.meds.gov.mn/>;
3. <https://www.uia.gov.mn/>;

---o0o---